

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
/ТНБД-ын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр
баталсан төлөвлөгөө/**

Зорилго 1.Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Батлан хамгаалах яам болон Авлигатай тэмцэх газартай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 08, 11, 25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журам, ёс зүй” сэдэвт сургалтын хүрээнд Авлигатай тэмцэх газрын “Олон нийтийн төв” цахим хуудсанд яам, түүний харьяа байгууллагуудын ажилтан, алба хаагчдыг хамруулж, авлигын эсрэг аян, санал, санаачилгад алба хаагчид нэгдсэн.

Зураг 1.Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудын бие бүрэлдэхүүнтэй хийсэн сургалт.



Зураг 2.ҮБХИС-ийн бие бүрэлдэхүүнтэй хийсэн сургалт.





Зураг 3.Цэргийн төв эмнэлгийн бие бүрэлдэхүүнтэй хийсэн сургалт.



-Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн “Судалгааны ажил гүйцэтгүүлэх тухай” 03/6832 дугаар албан бичиг, “Эс Ай Си Эс” ХХК-ийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Судалгаанд дэмжлэг хүсэх тухай” 01/215 дугаар албан бичгийн хүрээнд “Шударга байдлын үнэлгээ”-ний судалгааг яамны 30 алба хаагчаас авч, судалгааг хариуцсан холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

-Батлан хамгаалах яам, Авлигатай тэмцэх газрын хамтын ажиллагааны хүрээнд авлигын эсрэг мэдээ, мэдээллийн буланг “Соёмбо” сонинд бий болгох ажлыг санаачлан, АТГ-аас сонинд нийтлүүлэхээр ирүүлсэн шинэ мэдээ, мэдээллийг 2022 оны 06 дугаар сараас эхлэн нийтэлж байна.

-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдыг сонгон шалгаруулах, түүнийг зохион байгуулахад авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх, алба хаагчдаар авлига, ашиг, сонирхлын эсрэг хууль тогтоомжийг судлуулах талаарх Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 1в/3561 тоот “Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг ЗХЖШ-ын даргад хүргүүлсэн.

Зураг 4. Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай.

МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ
Засгийн газрын VII байр, Энхтайвны өргөн чөлөө 51,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13340
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 81 12,
Цахим хуудас: info@mod.gov.mn,
Цахим хуудас: www.mod.gov.mn

2022.09.28 № 1в/3561
танай _____ -ны № _____ -т

Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтын явцад энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах, түүнийг зохион байгуулах ажил, арга хэмжээтэй холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн мэдээллүүд эрх бүхий албан тушаалтанд ирдэг талаар дурдсан болно.

Иймд энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах болон түүнийг зохион байгуулахдаа алба хаагч нарыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигын эсрэг гэмт хэрэгт өртөхгүй байх чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллахыг ажил хариуцсан албан тушаалтанд даалгаж, дор дурдсан ажлыг хэрэгжүүлж ажиллана уу. Үүнд:



1. Алба хаагч өөрийгөө болон бусдыг авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс ангид байлгах мэдлэг олгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжоор сургалт зохион байгуулах;
2. Авлига, ашиг сонирхлын эсрэг хууль тогтоомжуудыг алба хаагч нараар судлуулж, мэдлэгийн сорилго авах, байгууллага дотроо авлигын эрсдэлийн үнэлгээ хийх;
3. Иргэд, олон нийтээс ил тод байдлыг хангах чиглэлээр мэдээлэл авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн байх;
4. Авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхгүй байж, энэ төрлийн зөрчил илэрсэн, түүнийг мэдсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх, илэрсэн зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг нэн даруй авах зэрэг болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ
Д.ГАНХУЯГ

-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2022 оны 10 дугаар сард зохион байгуулах намрын ээлжит цэрэг татлагын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх, алба

хаагчдаар хууль тогтоомжийг судлуулах талаарх Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 1в/3449 тоот “Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг Аймаг, нийслэлийн цэргийн штабын дарга нарт хүргүүлсэн.

Зураг 5. Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай.



Зорилго 2. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

–“Авлига, ашиг сонирхлын эсрэг хэрэгжүүлэх шуурхай төлөвлөгөө”-г 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, төлөвлөгөөнд тусгасан 4 ажил, арга хэмжээг 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжүүлсэн.

–Батлан хамгаалах яамны “Авлигын эрсдэлийг үнэлэх” ажлыг яамны ХШУДАГ-тай хамтран зохион байгуулах ажлын хүрээнд эрсдэлийн үнэлгээг хийх асуумжийг боловсруулж, алба хаагчдаас асуумжийг авч “Авлигын эрсдэлийг үнэлгээ”-ний тайланг ТНБД-аар илтгэх хуудсаар танилцуулсан.

Зураг 6. Авлигын эрсдэлийг үнэлэх асуумж.

АВЛИГЫН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр баталсан "Авлига, ашиг сонирхлын эсрэг хэрэгжүүлэх шуурхай төлөвлөгөө"-нд "Батлан хамгаалах яамны авлигын эсрэг эрсдэлийн үнэлгээг яамны ХШУДАГ-тай хамтран хийх" гэж заасныг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд энэхүү судалгааг боловсруулав.

Судалгааны зорилго: Байгууллагынхаа авлигын эрсдэлийн түвшинг тогтоох, эрсдэлийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлж, зөвлөмж боловсруулахад оршино.

1. Байгууллагын чиг үүрэг, бүтцийг үнэлэх асуулга:

-Танай байгууллага (газар, хэлтэс)-ын ямар албан тушаал авилгын эрсдэлтэй гэж та үздэг вэ?
 Б.Анхк.Мяг

-Танай байгууллагын авилгатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт хийдэг үү?
 1.Тийм 2. Үгүй 3.Заримдаа

-Байгууллагын авилгатай тэмцэх үйл ажиллагааны талаар алба хаагчдад эсхүл үйлчлүүлэгч, олон нийтэд зөвлөмж, мэдээлэл хүргэдэг үү?
 1.Маш бага 2.Бага 3.Дунд 4.Их 5.Маш их

-Танай байгууллагын аль үйл ажиллагаанд албан тушаалтан дангаараа шийдвэр гаргадаг вэ?
 Б.Анхк.Мяг

-Танай байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий алба хаагчид сонирхлын зөрчлөөс ангид байж чаддаг уу?
 1.Тийм 2.Үгүй.

-Албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчид ажлын байрны тодорхойлолт дахь шалгуурыг хэр хангаж байгаа гэж та дүгнэдэг вэ?
 1.Хангаж байна. 2.Хангахгүй байна. 3.Ихэнхи тохиолдолд хангадаг.
 4.Ихэнхи тохиолдолд хангаж чаддаггүй.

-Удирдах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчдын үйл ажиллагааны шат бүрт хяналт тавьж чаддаг уу?
 1.Маш бага 2.Бага 3.Дунд 4.Их 5.Маш их

-Үйл ажиллагаандаа ашиглаж буй дүрэм, журмын талаарх мэдээлэл ил тод байдаг уу?
 1.Тийм 2.Үгүй.

2. Ил тод байдлыг үнэлэх асуулга:

-Хууль тогтоомжийн дагуу ил тод байх ёстой мэдээлэл хангалттай ил тод байж чаддаг уу?
 1.Маш бага 2.Бага 3.Дунд 4.Их 5.Маш их

-Ил тод байгаа мэдээлэл иргэд, олон нийтэд ойлгомжтой, хангалттай ил тод байж чаддаг уу?
 1.Маш бага 2.Бага 3.Дунд 4.Их 5.Маш их

-Сүүлийн нэг жилийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгжээс мэдээлэл хүссэн хүсэлт, өргөдөл та хүлээн авсан уу?
 1.Маш бага 2.Бага 3.Дунд 4.Их 5.Маш их

3. Ёс зүйн болон шударга ёсны тогтолцоог үнэлэх асуулга:

-Цэргийн төв эмнэлэг нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар "Би авлига өгөхгүй, Би авлига авахгүй", "Авлигатай тэмцэх газар 110", "Өгөхгүй бай, нэхвэл илчил", "Шударга ёс, хөгжил дэвшил" зэрэг ухуулга, сурталчилгааны хуудсыг байгууллагынхаа өрөө тасалгаануудад байршуулж, авлигын эсрэг хууль тогтоомжуудын эмхэтгэл сургалтын гарын авлагыг боловсруулан ашигласан.

Зорилго 3. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2022 онд хэрэгжүүлэх Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлуулж, яамны цахим хуудас дахь авлигын эсрэг цэсэд байрлуулсан.

Зураг 7. Авлига, ашиг сонирхлын эсрэг хэрэгжүүлэх шуурхай төлөвлөгөө

Д/а	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ХУГАЦАА	ХҮРЭГ ӨР ДИГ
1.	Батлан хамгаалах яамны зарим байгууллагуудын авилгын асуудал хөрүүдэд дахь бусад албан тушаалтнуудтай авилгас эрх зөвлөмж урьдчилан сэргийлэх, соёл гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.	2022.10.20.	Албан тушаалтнууд, сургалтанд бүрэн хамрагдан, авилгас эрх зөвлөмж урьдчилан сэргийлэх, соёл гэгээрүүлэх чиглэлээр андууриг олох ажил байна.
2.	Батлан хамгаалах яамны авилгын эсрэг эрсдэлийн үнэлгээг яамны ХШУДАГ-тай хамтран хийх.	2022.11 сард	Авлигын эрх зөвлөмж урьдчилан сэргийлэх ажил байна.
3.	Авлигатай тэмцэхийг гэмдэн, мэдээллийг хүлээн авах утас 118-ын логог болон авилгас эрх зөвлөмж урьдчилан сэргийлэх чиглэлээр болон хэмжээний шударга ёсны тухай 120г-тай хамтран бэлтгэх яамны цахим хуудасг байршуулах.	2022.11 сард	Батлан хамгаалах яамны цахим хуудасг байршуулах ажил байна.
4.	Авлига, нийслэлийн цэргийн шалбын үндэслэлээр "Авлигас эрх зөвлөмж урьдчилан сэргийлэх, соёл гэгээрүүлэх" чиглэлээр хэрэгжүүлэх үүрэг, чиглэлийг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулан хэрэгжүүлэх.	2022.09.19.	Түрэг, чиглэл хүргэгчид, хамрагчид арга хэмжээ авчигдсан байна.


 ТӨРӨН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
 БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д.ГАНБОРИГ
 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдөр

АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШУУРХАЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН
 ХУУЛЬЧ ЭХЭТЭЙН АХЛАХ
 МЭРГЭЖИЙТЭН С.Ойго

ЗОХИОН
 СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨГӨӨН
 ДАРГА, ХУРАНДАА Ч.ГАНДИРВАА

-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэж Авлигатай тэмцэх газрын www.khutulbur.iaac.mn цахим хуудсанд байршуулсан.

-Батлан хамгаалах яамны авлигын эсрэг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг гаргаж, холбогдох мэдээллийн хамт Батлан хамгаалах яамны www.mod.gov.mn-д, Авлигатай тэмцэх газрын цахим сан (www.khutulbur.iaac.mn)-д албан бичигт заасан хугацаанд тайлагнасан.

-Батлан хамгаалах яам, харьяа байгууллагуудаас Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 1в/852 тоот “Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг ирүүлэх тухай” албан бичгийг харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлж, авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны эхний хагас жилийн тайлангуудыг нэгтгэн АТГ-т хүргүүлсэн.

Зураг 8. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хүргүүлэх тухай албан бичиг.




-Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, сурталчилгааны баннер, богино хэмжээний 2022 оны эхний хагас жилд шинээр гарсан видео контентуудыг яамны цахим хуудсанд байршуулж, мэдээлэл, сурталчилгааны зураг, бусад материалыг Батлан хамгаалах яам, харьяа аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан. Тухайлбал: Ирээдүйг хамгаалах, хайрлах хамгийн зөв арга бол авлигыг тэвчих, Авлигын гэмт хэргийн ялын бодлого зэрэг болно.

-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр баталсан “Авлига, ашиг сонирхлын эсрэг хэрэгжүүлэх шуурхай төлөвлөгөө”-ний 3-т “Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний шторкийг хийж, цахим


хуудаст байршуулах” гэж заасны дагуу “Батлан хамгаалах салбар авлигагүй орчин” сэдэвт богино хэмжээний шторкийг Дуулга студтэй хамтран хийж яамны цахим хуудаст болон Дуулга студын цахим хуудаст тус тус байршуулсан.

Зураг 9. Батлан хамгаалах салбар авлигагүй орчин сэдэвт шторк



-Батлан хамгаалах яамны www.mod.gov.mn вэб сайтад болон ЗХЖШ, ҮБХИС, Цэргийн төв эмнэлэг, Батлан хамгаалах ын төв архив зэрэг байгууллагуудын цахим хуудаст “Авлигыг мэдээлэх 110” дугаарын утасны логог байршуулах ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулуунд мэдэгдсэн.

Зураг 10. Батлан хамгаалах яамны www.mod.gov.mn вэб сайтад “Авлигыг мэдээлэх 110” дугаарын утасны логог байршуулсан.



-Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, Ёс зүйн зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Авлигатай тэмцэх газартай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 08, 11-ний өдөр Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын /УБХИС, Бөртэ, ЦТЭ, ХЗЦК, бусад харьяа байгууллага/ нийт 750 албан хаагчид “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журам болон ёс зүй” сэдэвт сургалтыг /АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулуун, М.Жамьянцоожил, Б.Тэрбиш/ зохион байгуулсан.

-Батлан хамгаалах яамны “Авлигын эсрэг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хүрээнд Авлигатай тэмцэх газартай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр яамны нийт бие бүрэлдэхүүнд “Авлигын шалтгаан нөхцөл, хөрөнгө орлогын мэдүүлэх мэдүүлэхэд анхаарах асуудал”, “Авлигын шалтгаан нөхцөл, хөрөнгө орлогын мэдүүлэх мэдүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.

-АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулуун, мөн газрын Хяналт-шалгалтын хэлтсийн комиссар Бат-Очир нар хичээл заасан.

Зураг 11.Батлан хамгаалах яамны алба хаагчид хамрагдсан сургалт.



-Авлигатай тэмцэх газраас 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Авлигын нөхцөл байдал ба авлигаас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад ахлах мэргэжилтэн Л.Ганзориг, яамны харьяа байгууллагуудын хуулийн асуудал хариуцсан албан тушаалтнуудтай хамрагдаж, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгээ дээшлүүлсэн. Сургалтын талаарх мэдээллийг Төрийн нарийн бичгийн даргад илтгэх хуудсаар танилцуулсан.

Зураг 12.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын нөхцөл байдал ба авлигаас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт.



-Авлигаас урьдчилан сэргийлэх, иргэдийн санал, гомдлыг хүлээн авах чиглэлээр Авлигатай тэмцэх газрын “Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа” мэдээллийн салбарыг байршуулж, иргэд олон нийтийн мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн ба яамны цахим хуудас дахь Авлигын эсрэг цэсийг

шинэчлэн Авлигатай тэмцэх газраас авч хэрэгжүүлж байгаа сурталчилгааны материал, шторк, баннерыг байрлуулж, тус газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй тогтмол холбоотой хамтран ажиллаж байна.

-Батлан хамгаалахын сайдын 2022 оны 05 дугаар сарын 03, 12-ны өдөр баталсан ҮБХИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудыг хянан шалгах ажлын хүрээнд “Хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилт, ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-г хянан шалгаж, дүнг Батлан хамгаалахын сайдад танилцуулсан.

Уг шалгалтын дүнд үндэслэн ҮБХИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, холбогдох ажил, арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон нотломжийг хүргүүлсэн.

Зорилго 5.Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс болон бусад хэлтсээс Авлигын эсрэг сургалт зохион байгуулахад алба хаагчдыг тогтмол бүрэн хамруулж байна.

-Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллагын нийт 950 албан хаагчид “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журам болон ёс зүй” сэдэвт сургалтыг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулсан.

-Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Аюулгүй байдлын дээд сургуулийн нийт 450 гаруй оюутнуудыг хамруулсан “Таны эрх, таны оролцоо-Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” сэдэвт сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулсан.

-Мөн тус сургуулийн бүтцийн нэгжүүдийн дунд “Өнөөдрийн үйл маргаашийн бахархал”, “Бүхний түрүүнд бүгдийг эхэл” аян өрнүүлэх захирлын тушаал, удирдамж батлуулж, авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

-Батлан хамгаалахын төв архивын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 452 тоот албан бичгийн хүрээнд “Авлига, ашиг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдэвт” сургалтыг тус байгууллагын нийт алба хаагчдад ахлах мэргэжилтэн Л.Ганзориг зохион байгуулж явуулсан.

-Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллагуудын болон ЗХЖШ-ын харьяа нэгтгэл, анги, байгууллагуудын Хуулийн зөвлөх, хуулийн офицеруудад 2022 оны 10 сарын 12-ны өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн үзүүлэн тараах материалыг алба хаагчид өгсөн болно. Тус сургалтын талаар цахим “Соёмбо” сонинд нийтлэгдсэн.

Зураг 13. Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллагуудын болон ЗХЖШ-ын харьяа нэгтгэл, анги, байгууллагуудын Хуулийн зөвлөх, хуулийн офицеруудад “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт.



Зорилго 6. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд гарсан ололт, амжилт, биелэлтийн үр нөлөөний талаар холбогдох дүгнэлтийг гаргаж ирүүлэх тухай Авлигатай тэмцэх газрын албан бичигтэй танилцаад, холбогдох мэдээллийг цаашид хэрэгжүүлэх ажлын талаарх саналын хамт боловсруулж, хариуг тус газарт хүргүүлсэн.

-Авлигатай тэмцэх газар, мөрдөгчөөс ирүүлсэн зөвлөмж, мэдэгдэл ирээгүй, тус газрын мөрдөн шалгах хэлтсээс зарим нэг алба хаагчдын ХОМ-ийг ирүүлэх тухай хүсэлттэй танилцаад, хэрэгжилтийг ханган ажилласан.

-Батлан хамгаалахын сайдын 2022 оны 06 дугаар 06-ны 1а/2163 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр ЗХЖШ, харьяа аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал нарт “Алба хаагч нар өөртөө давуу байдал бий болгох зорилгоор албан тушаалд томилуулах, сургууль, дамжаанд суралцах, ЭДА-нд оролцох, төрийн одон медалиар шагнуулах, цол олгуулах, орон сууцны дэмжлэг хүсэх зэрэг асуудлаар Төрийн болон бусад эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан хэлүүлэх үйлдэл гаргахгүй байх, дээрх үйлдлийг гаргасан алба хаагчдад хууль тогтоомжид заасан хариуцлага тооцох” талаар чиглэл хүргүүлсэн.

Зорилго 7.Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсны үндсэн зохих албан тушаалд томилох, хэрэгжилтийг зохион байгуулах.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 180 гаруй алба хаагчийн “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг хүлээн авч нягтлан, хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

-Авлигатай тэмцэх газрын дүгнэлт гаргуулсны дараа алба хаагчдыг тухайн албан тушаалд нь томилох ажилд хяналт тавин ажиллаж байна.

-Батлан хамгаалах яам, түүний харьяа аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг” гаргах алба хаагчдын нэрийн жагсаалтыг нэгтгэж, 545 алба хаагчийн ХАСХОМ-ийг гаргуулж, холбогдох журам, зааврын дагуу нэгтгэж, тайланг Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Зорилго 8.Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, зөвлөгөө, мэдээлэл өгөх, хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч, хуулийн хугацаанд хянан шийдвэрлэхэд хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. Тухайлбал:Цэргийн төв эмнэлгээс нэр бүхий 3 ажилтны гомдлыг АТГ-т шалгуулахаар хүргүүлсэн байна.

-Батлан хамгаалах салбартай холбоотой иргэдээс гаргасан санал, хүсэлт, гомдлыг 18001144 дугаарт байнга хүлээн авч байна. Тухайлбал: БЗД-ийн 13-р хорооны иргэнээс ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн 4-р курсийн оюутанд холбогдуулан гаргасан гомдлыг судлан үзэж, холбогдох хариуг утсаар өгсөн.

Зорилго 9.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Яам, түүний харьяа байгууллагуудын нууцад хамааруулснаас бусад мэдээлэл, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй хүргэж, байгууллагынхаа цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээг тогтмол тусгасан эсэхэд хяналт тавьж ажилласан.

-Авлигатай тэмцэх газартай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 08, 11-ний өдөр зохион байгуулсан сургалтын талаарх мэдээ, мэдээллийг ҮБХИС, Бөртэ, ЦТЭ зэрэг байгууллагуудын цахим хаягт байршуулсан эсэхэд хяналт тавьж, мэдээ, мэдээллийг сайтад бүрэн тусгуулсан.

-Тус сургалтын талаарх мэдээллийг Соёмбо сонинд нийтлүүлж, Дуулга студийн “Эх орны төлөө” нэвтрүүлгээр гаргах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

-Мөн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлан хамгаалах салбараас баримталж ажиллах ажил, арга хэмжээний талаарх мэдээллийг боловсруулж, Соёмбо сонинд нийтлүүлсэн.

ТАЙЛАНГИЙН НИЙТ ХЭРЭГЖИЛТ 94 ХУВЬТАЙ ДҮГНЭГДЭВ.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

СБТГ-ЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, АВЛИГЫН АСУУДАЛ

ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Л.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:

СБТГ-ЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Г.ЭНХБОЛД

ТАНИЛЦСАН:

СБТГ-ЫН ГАЗРЫН ДАРГА ХУРАНДАА

Ч.ГАНДИРВАА

АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШУУРХАЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
/ТНБД-ЫН 2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР
БАТАЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ/

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1.Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудын авлигын асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудтай авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллагуудын болон ЗХЖШ-ын харьяа нэгтгэл, анги, байгууллагуудын Хуулийн зөвлөх, хуулийн офицеруудад 2022 оны 10 сарын 12-ны өдөр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн үзүүлэн тараах материалыг алба хаагчид өгсөн болно. Тус сургалтын талаар цахим “Соёмбо” сонинд нийтлэгдсэн. ХЭРЭГЖИЛТ 100 ХУВЬ

Зураг 1.Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллагуудын болон ЗХЖШ-ын харьяа нэгтгэл, анги, байгууллагуудын Хуулийн зөвлөх, хуулийн офицеруудад “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт.



Хэрэгжүүлэх арга хэмжээ 2.Батлан хамгаалах яамны авлигын эрсдэлийг үнэлэх ажлыг яамны ХШҮДАГ-тай хамтран хийх.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Батлан хамгаалах яамны “Авлигын эрсдэлийг үнэлэх” ажлыг яамны ХШҮДАГ-тай хамтран зохион байгуулах тухай газрын дотоод албан бичгийг 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ХШҮДАГ-т хүргүүлж, эрсдэлийн үнэлгээг хийх асуумжийг ХШҮДАГ-тай хамтран боловсруулж, алба хаагчдаас асуумжийг авч “Авлигын эрсдэлийг үнэлгээ”-ний тайланг ТНБД-д илтгэх хуудсаар танилцуулсан. ХЭРЭГЖИЛТ 100 ХУВЬ

Зураг 2. Авлигын эрсдэлийг үнэлэх асуумж.

АВЛИГЫН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр баталсан "Авлига, ашиг сонирхлын эсрэг хэрэгжүүлэх шуурхай төлөвлөгөө"-нд "Батлан хамгаалах яамны авлигын эсрэг эрсдэлийн үнэлгээг яамны ХШҮДАГ-тай хамтран хийх" гэж заасныг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд энэхүү судалгааг боловсруулав.

Судалгааны зорилго: Байгууллагынхаа авлигын эрсдэлийн түвшинг тогтоох, эрсдэлийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлж, зөвлөмж боловсруулахад оршино.

1. Байгууллагын чиг үүрэг, бүтцийг үнэлэх асуулаа:

-Танай байгууллага (газар, хэлтэс)-ын ямар албан тушаал авилгын эрсдэлтэй гэж та үздэг вэ?
 Сайнхуяа

-Танай байгууллагын авилгатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт хийдэг үү?
 1. Тийм 2. Үгүй 3. Заримдаа

-Байгууллагын авилгатай тэмцэх үйл ажиллагааны талаар алба хаагчдад эсхүл үйлчлүүлэгч, олон нийтэд зөвлөмж, мэдээлэл хүргэдэг үү?
 1. Маш бага 2. Бага 3. Дунд 4. Их 5. Маш их

-Танай байгууллагын аль үйл ажиллагаанд албан тушаалтан дангаараа шийдвэр гаргадаг вэ?
 С.Батхур

-Танай байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий алба хаагчид сонирхлын зөрчлөөс ангид байж чаддаг уу?
 1. Тийм 2. Үгүй.

-Албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчид ажлын байрны тодорхойлолт дахь шалгуурыг хэр хангаж байгаа гэж та дүгнэдэг вэ?
 1. Хангаж байна. 2. Хангахгүй байна. 3. Ихэнхи тохиолдолд хангадаг.

4. Ихэнхи тохиолдолд хангаж чаддаггүй.

-Удирдах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчдын үйл ажиллагааны шат бүрт хяналт тавьж чаддаг уу?
 1. Маш бага 2. Бага 3. Дунд 4. Их 5. Маш их

-Үйл ажиллагаандаа ашиглаж буй дүрэм, журмын талаарх мэдээлэл ил тод байдаг уу?
 1. Тийм 2. Үгүй.

2. Ил тод байдлыг үнэлэх асуулаа:

-Хууль тогтоомжийн дагуу ил тод байх ёстой мэдээлэл хангалттай ил тод байж чаддаг уу?
 1. Маш бага 2. Бага 3. Дунд 4. Их 5. Маш их

-Ил тод байгаа мэдээлэл иргэд, олон нийтэд ойлгомжтой, хангалттай ил тод байж чаддаг уу?
 1. Маш бага 2. Бага 3. Дунд 4. Их 5. Маш их

-Сүүлийн нэг жилийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгжээс мэдээлэл хүссэн шийдэл, өргөдөл та хүлээн авсан уу?
 1. Маш бага 2. Бага 3. Дунд 4. Их 5. Маш их


3. Ёс зүйн болон шударга ёсны тогтолцоог үнэлэх асуулаа:

Хэрэгжүүлэх арга хэмжээ 3. Авлигатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах утас 110-ын логог болон авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний шторкийг яамны ТЗУГ-тай хамтран бэлтгэж яамны цахим хуудаст байршуулах.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Батлан хамгаалах яамны www.mod.gov.mn вэб сайтад болон ЗХЖШ, ҮБХИС, Цэргийн төв эмнэлэг, Батлан хамгаалах ын төв архив зэрэг байгууллагуудын цахим хуудаст "Авлигыг мэдээлэх 110" дугаарын утасны логог байршуулах ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулуунд мэдэгдсэн.


Зураг 3. Батлан хамгаалах яамны www.mod.gov.mn вэб сайтад "Авлигыг мэдээлэх 110" дугаарын утасны логог байршуулсан.



-Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр баталсан “Авлига, ашиг сонирхлын эсрэг хэрэгжүүлэх шуурхай төлөвлөгөө”-ний 3-т “Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний шторкийг хийж, цахим хуудаст байршуулах” гэж заасны дагуу “Батлан хамгаалах салбар авлигагүй орчин” сэдэвт богино хэмжээний шторкийг Дуулга студитэй хамтран хийж яамны цахим хуудаст болон Дуулга студийн цахим хуудаст тус тус байршуулсан.

ХЭРЭГЖИЛТ 100.

Зураг 4.Батлан хамгаалах салбар авлигагүй орчин сэдэвт шторк ХУВЬ




Хэрэгжүүлэх арга хэмжээ 4.Аймаг, нийслэлийн цэргийн штабын удирдлагуудад “Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” чиглэлээр холбогдох үүрэг, чиглэлийг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулан хүргүүлэх.


Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдыг сонгон шалгаруулах, түүнийг зохион байгуулахдаа авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх, алба хаагчдаар авлига, ашиг, сонирхлын эсрэг хууль тогтоомжийг судлуулах талаар Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 1в/3561 тоот “Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг ЗХЖШ-ын даргад хүргүүлсэн.

Зураг 4. Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай.



Зураг 5. Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай.



-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2022 оны 10 дугаар сард зохион байгуулах намрын ээлжит цэрэг татлагын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх, алба хаагчдаар хууль тогтоомжийг судлуулах талаар Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 1в/3449 тоот “Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг Аймаг, нийслэлийн цэргийн штабын дарга нарт хүргүүлсэн. ХЭРЭГЖИЛТ 100 ХУВЬ.

ТАЙЛАНГИЙН НИЙТ ХЭРЭГЖИЛТ 100 ХУВЬТАЙ ДҮГНЭГДЭВ.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

СБТГ-ЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, АВЛИГЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Л.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:

СБТГ-ЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
ЯАМНЫ ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Г.ЭНХБОЛД

ТАНИЛЦСАН:

СБТГ-ЫН ГАЗРЫН ДАРГА ХУРАНДАА

Ч.ГАНДИРВАА

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ